

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Харилцаа холбооны тухай хуулийн дараах хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэг:

“8.3.Зохицуулах хорооны дарга, гишүүнийг Ерөнхий сайд томилох бөгөөд гишүүнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус 2, Худалдаа, аж үйлдвэрийн танхим, иргэний нийгмийн төлөөллөөс тус бүр 1 нэр дэвшигчийг санал болгоно.”

2/8 дугаар зүйлийн 8.6, 8.6¹ дахь хэсэг:

8.6.Зохицуулах хорооны гишүүнээр дараах шаардлагыг хангасан Монгол Улсын иргэнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр томилно:

8.6.1.харилцаа холбоо, мэдээллийн технологи, эдийн засаг, эрх зүйн чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй;

8.6.2.харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарт мэргэжлээрээ 8-аас доошгүй жил ажилласан байх;

8.6¹.1.Зохицуулах хорооны даргаар дараах шаардлагыг хангасан Монгол Улсын иргэнийг томилно:

8.6¹.1.1.харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй;

8.6¹.1.1.харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарт 12-оос доошгүй жил, үүнээс 5-аас доошгүй жил удирдах албан тушаалд ажилласан байх.

8.6.2.Зохицуулах хорооны дарга, гишүүн нь үйлчлэгчийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаар эзэмшигч, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд байж болохгүй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны ... сарын ... ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

